

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Монложистикс Холдинг ХК (цаашид “Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх) 2026 оны 4-р сарын 25-ны өдрийн 11 цаг 00 минутад эхлэв. Хурлыг БиДиСек ҮЦК ХК-ийн хөгжүүлсэн хувьцаа эзэмшигчдийн хурлын платформыг ашиглан зайнаас буюу цахим хэлбэрээр хуралдуулж, шууд дамжуулалтыг Пексимедиа ХХК-ийн тусламжтайгаар хурлын платформоор болон фэйсбүүк дэхь Monlogistics Group пэйж хуудсаар хүргэв.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн нарийн бичгийн дарга бөгөөд Хурал зохион байгуулах комиссын дарга Ц. Дуламсүрэн хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчидтэй мэндчилэн, хуралд оролцогчдыг танилцуулсаны дараа хурлын дэгийг танилцуулан хурлыг эхлүүлэв.

Хуралд биечлэн оролцсон:

1. Гүйцэтгэх захирал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Г. Хишигбат;
2. ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудит, Эрсдэлийн удирдлагын хорооны дарга Э. Оюунбилэг;
3. Хөндлөнгийн аудитор Грант Торнтон ХХК-ийн аудитын багийн гэрээт ажлын партнер Н. Эрдэнэцог;

Хурлын тооллогын комисс:

1. Комиссын дарга, Захиргааны менежер Э. Нарангарвуу;
2. Комиссын гишүүн, Хүний нөөцийн мэргэжилтэн О. Онон;
3. Комиссын гишүүн, Бизнесийн шинжээч Д. Нямжанцан;

Хурлын нарийн бичгийн дарга:

1. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ц. Дуламсүрэн;

Хурлын дэгийн дагуу Тооллогын комиссын дарга Э. Нарангарвууг хурлын ирцийг танилцуулав.

Хурлын ирц: Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг бүртгэлийн өдрөөр тасалбар болгон гаргахад нийт хуралд оролцох эрхтэй 370,882,927 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг 4,873 хувьцаа эзэмшигч байснаас хуралд 324,133,121 ширхэг энгийн хувьцаа бүхий 26 хувьцаа эзэмшигч оролцож, хурлын ирц 87.39 хувь болж байгаа тул хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай Тооллогын комиссын тогтоолыг Хурлын даргад танилцуулав.

Ирц бүрдсэн тул компанийн Гүйцэтгэх захирал бөгөөд Хурлын дарга Г. Хишигбат хурлыг нээж үг хэлэн, хэлэлцэх асуудлуудыг танилцуулав.

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Монложистикс Тракинг ХХК-ийг Монложистикс Холдинг ХК-тай нэгтгэх асуудлыг хэлэлцэж батлах;

Хэлэлцсэн нь:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Монложистикс Тракинг ХХК-ийг Монложистикс Холдинг ХК-тай нэгтгэх асуудлыг хэлэлцэж батлах;

Танилцуулсан нь:

Хурлын дарга Г. Хишигбат хурлын нээж хэлсэн үгэндээ “Өнгөрсөн хугацаанд хамтран ажиллаж ирсэн нийт харилцагчид, хамтран ажиллагч түншүүд, ажилтнууд, ялангуяа компанид итгэл хүлээлгэсэн хувьцаа эзэмшигч нартаа талархал илэрхийлэв. 2025 он бол Монложистикс группийн хувьд МУ-ын тээвэр ложистикийн салбарт тасралтгүй үйл ажиллагаа явуулсаны 20 жилийн ой тохиосон онцлог жилээс гадна дэлхийн хэмжээнд геополитикийн таагүй нөхцөл болон худалдааны бодлого тодорхойгүй, нийлүүлэлтийн сүлжээ тасалдах эрсдэлтэй орчинд бид үйл ажиллагаагаа явуулж, МУ-ын хувьд дотоод эдийн засгийн идэвхжил суларсан, тээврийн салбарын орлого буурсан, үнийн өрсөлдөөн ширүүссэн, боомтуудын нэвтрүүлэх хүчин чадал хүрэлцээгүй гээд олон саад бэрхшээл, сорилтуудтай жил байсныг онцлов. Гэсэн хэдий ч бид өнгөрсөн 20 жилийн адилаар урагш харж, эдгээр эрсдэлүүдийг боломж болгон, стратегийн томоохон ажлууд, технологийн шийдлүүдийг сайжруулах дижитал шилжилт дээр төвлөрч ажиллаж байна зэргээр МУ-ын тээвэр ложистикийн салбарын онцлох ач холбогдолтой ажлууд, компанийн алсын хараа, урт хугацааны үнэ цэнийг бий болгоход чиглэсэн стратегийн ажлууд дээр төвлөрч, хувьцаа эзэмшигч нарынхаа бидэнд өгсөн итгэлийн хариуг ажлын үр дүнгээр харуулна” гэдгээ онцлон тэмдэглэв.

Хурлын дэгийн дагуу хэлэлцэх 2 асуудлын танилцуулав.

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Монложистикс Тракинг ХХК-ийг Монложистикс Холдинг ХК-тай нэгтгэх асуудлыг хэлэлцэж батлах;

Үргэлжлүүлэн Монложистикс группийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав. 2026 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр үйл ажиллагааны жилийн тайланг Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, компанийн хувьцаа эзэмшигч нарт зориулсан цахим хуудас, пэйж хуудас зэрэгт байршуулсан гэдгийг тодотгоод, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо өнгөрсөн жилээс 2500-р нэмэгдэж, 5000 орчим хувьцаа эзэмшигчидтэй болсон тул Монложистикс Холдинг ХК-ийн болон Монложистикс группийн талаар, үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй танилцуулга хийж, группийн бүтцийг танилцуулахдаа Монложистикс Экспресс ХХК болон

Монложистикс Тракинг ХХК-иудын үйл ажиллагааг Монложистикс Ворлдвайд ХХК-д нэгтгэж, харин хуулийн этгээдийн тухайд өнөөдрийн хурлаар Монложистикс Тракинг ХХК-ийг нэгтгэх тухай асуудлыг хэлэлцэж байгаа гэдгийг танилцуулав.

2025 оны үндсэн үйл ажиллагааны голлох тоон үзүүлэлтүүд болон санхүүгийн тайлангийн голлох үзүүлэлтүүдийг дэлгэрэнгүй танилцуулж, санхүүгийн дэлгэрэнгүй тоон үзүүлэлтийг МХБ-ийн болон компанийн цахим хуудаст байршуулсан санхүүгийн аудитлагдсан тайлангаас үзэж танилцах боломжтойг сануулав. Мөн 2025 оны онцлох үйл явдлууд, онцлох тээврүүд, дэлхийн болон МУ-ын тээвэр ложистикийн зах зээлийн төлөв байдал, ирээдүйн чиг хандлагын талаар мэдээлэл өгөв.

Ногдол ашиг тараах тухай болон хувьцаа эргүүлэн худалдан авч, халааслах тухай ТУЗ-өөс гаргасан шийдвэр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг дэлгэрэнгүй танилцуулав.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын дэлгэрэнгүй танилцуулга хийж, татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 50 ширхэг хагас вагон буюу нэг цуваа хөдлөх бүрэлдэхүүнтэй болсныг танилцуулаад, эдийн засгийн нөхцөл байдал, төмөр замын ачаалал, төмөр замын тээврийн тухай хууль бүрэн хэрэгжиж эхлээгүй байгаа талаар тайлбар мэдээлэл өгч, цаашид 50 ширхэг вагон нэмж авах төлөвлөгөө тавин ажиллаж байгаа тухай танилцуулав. Мөн татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 3,5 тэрбум төгрөгийг Төв Азийн Зам ХХК-ийн 51%-ийг эзэмшиж, хувьцааг худалдан авахад зарцуулсан нь группийн орлого болон бусад үзүүлэлтэд хэрхэн эерэг үр нөлөөг бий болгосон тухай дэлгэрэнгүй танилцуулав.

Нэмээд Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд хийсэн ажлуудыг дэлгэрэнгүй танилцуулав.

Хурлын дарга Г. Хишигбат компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулсаны дараа хөндлөнгийн аудитор Грант Торнтон Аудит ХХК-ийн аудитын багийн гэрээт ажлын партнер Н. Эрдэнэцог санхүүгийн тайлангийн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг танилцуулж, Г. Хишигбат захирлын танилцуулсан санхүүгийн тайлан бол аудитлагдсан бөгөөд зөрчилгүй гэсэн дүгнэлттэй тайлан гэдгийг баталгаажуулав.

ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудит, Эрсдэлийн удирдлагын хорооны дарга Э. Оюунбилэг ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүйг тодотгоод, ТУЗ-ийн хурлууд, ирц, ТУЗ-өөс гаргасан шийдвэр, ТУЗ-ийн өөрийн үнэлгээ болон КЗК-ийн үнэлгээ, дотоод хяналтын тогтолцооны талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөв.

Хурлын дэгийн дагуу хурлын дарга Г. Хишигбат Монложистикс Холдинг ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 4 дүгээр сарын 20-ний өдрийн №26/ТУЗ/21 тоот тогтоолоор батлагдсан “2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Монложистикс Холдинг ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон СТОУС-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланд Монгол Улсын Аудитын тухай хуулийн дагуу хөндлөнгийн аудит хийж ажилласан “Грант Торнтон Аудит” ХХК-ийн Хараат бус аудиторын дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй”, “Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланг “Хангалттай” гэж дүгнэсүгэй” гэсэн дүгнэлтийг болон 2026 оны 4 дүгээр сарын 20-ний өдрийн №26/ТУЗ/22 тоот тогтоолоор батлагдсан “Монложистикс Тракинг ХХК-ийг Монложистикс Холдинг ХК-тай нэгтгэх тухай

шийдвэрийн төсөл болон компанийг нэгтгэх гэрээний төслийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулах тухай” гэсэн тогтоолуудыг уншиж танилцуулав.

Хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудалтай болон компанийн үйл ажиллагаатай холбоотой асуулт хариултын цаг эхлэв.

Хувьцаа эзэмшигчдээс дараах асуултууд ирсэнийг танилцуулав.

1. Иргэн Мөнхтулга: Өнгөрсөн жил хувьцаа эргүүлэн худалдаж авна, 210 төгрөг хүртэл гэж байсан. 12 дугаар сарын 31-нийг хүртэл авна гэж мэдэгдсэн, гэтэл яагаад энэ мэдэгдлийнхээ дагуу хийгээгүй вэ? Одоо хувьцааны үнэ 173 төгрөг хүртэл унасан байна, ямар арга хэмжээ авах вэ?

Хурлын дарга Г. Хишигбат хариулсан нь:

Хувьцаа эргүүлэн худалдан авч, халааслах хөтөлбөр хэрэгжүүлэхээр ТУЗ-өөс баталсан. Анх удаа хэрэгжүүлж байгаа хөтөлбөр учир Мандал ассет менежмент ХХК буюу бидний ПРО хийх үеийн андеррайтер компаниас зөвлөгөө авч, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд хувьцаа эргүүлэн авч, халааслахын гол зорилго бол хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх болохоос биш үнийг зохиомлоор өсгөх биш, иймд 12 дугаар сарын 31-ний дотор шахааж авахаар үнийг тодорхой хэмжээнд хиймлээр өсгөнө гэж ТУЗ дээр хэлэлцээд, хугацааг сунгах шийдвэр гаргасан, цаашид энэ хөтөлбөрийг дахин хэрэгжүүлэх эсэх нь ТУЗ-ийн бүрэн эрхийн асуудал юм, хэрэв ТУЗ-өөс хөтөлбөрийг дахин үргэлжлүүлэх шийдвэр гаргавал тухай бүрт нь олон нийтэд нээлттэй мэдэгдээд явна.

3. Иргэн Бямбадэлгэр: Ирэх 3-5 хөгжлийн хугацаанд танай группийн хөгжлийн гол чиглэлүүдийг товч хуваалцаж өгч болох уу?

Хурлын дарга Г. Хишигбат хариулсан нь:

Ирэх 3-5 жилийн тухайд 2030 он хүртэлх ерөнхий стратеги дээрээ шинэчлэлт хийхээр ажиллаж байна, учир нь гадаад орчин ихээр өөрчлөгдөж байна, тэдний нэг нь Богд уулын төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор Монложистикс групп нь богино, дунд хугацааны стратегидээ өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Үүнд: одоо бий болгосон импорт, экспорт, транзит тээврийн сегментүүд дээрээ төвлөрч, ингэхдээ сегмент бүрийнхээ №1 компани нь болох зорилго тавьж, ингэхийн тулд импортын тээврийн хувьд 4PL загварт шилжих, агуулахын болон терминалын хөрөнгө оруулалт хийх, транзит тээврийн хувьд гэхэд бид өнгөрсөн хугацаанд “Тээвэр түншлэл” компанийн хамтарсан хөрөнгө оруулагч болсон бөгөөд энэ компани нь Замын-Үүдийн хуурай боомтын төсөл хэрэгжүүлнэ, энэ нь Замын-Үүд боомтын шилжүүлэн ачих хүчин чадлыг нэмэгдүүлэх, ингэснээр транзит зах зээл тэлнэ гэсэн хүлээлттэй байна, экспортын зах зээлийн хувьд вагоны тоог нэмэгдүүлнэ, Оюу толгойн зэсийн баяжмалыг төмөр замаар тээвэрлэх асуудлыг холбогдох төрийн байгууллагуудын зөвшөөрлийг авч, явуулах зэрэг олон томоохон ажлуудыг төлөвлөж хэрэгжүүлж байна.

Эдгээр ажлууд дээр нэмэгдэх нь манай дижитал шилжилтийн ажлууд, өнгөрсөн 2 жилийн хугацаанд core system-үүдийг шинэчлэх, сайжруулах ажлууд хийгдсэн, одоо үүнийгээ гадаад агентууд, бусад холбогдох талуудтай системтэйгээр холбох ажлууд хийгдэнэ.

4. Иргэн Бямбадэлгэр: Нэгтгэлийн ач холбогдол, эдийн засгийн үр ашиг гээд тодорхой тайлбар хэлж өгнө үү. Энэ компани нь ямар үйл ажиллагаа явуулдаг, санхүү үр ашиг нь ямар байгаа гээд мэдээлэл өгмөөр байна, нэгтгэж байгааг нь ойлголоо.

Хурлын дарга Г. Хишигбат хариулсан нь:

Монложистикс Тракинг компани нь өөрийн эзэмшлийн автомашинтай, түүгээрээ болон туслан гүйцэтгэгчээр дамжуулан автын тээврийг зохион байгуулдаг, гол харилцагч нь Монложистикс Ворлдвайд ХХК байсан, автын тээврийн зах зээл дээрээ төвлөрч, үр дүн гаргаж, өсөлттэй, ашигтай ажиллаж, ноу хау, туршлагыг хуримтлуулан ажилласан компани байгаа. Нэгтгэх шалтгаан нь өмнө хэлсэнчлэн бүтээмжийн болон оновчтой зохион байгуулалтыг сайжруулах шаардлага юм. Санхүүгийн хувьд эдгээр компаниуд бүгд ашигтай ажиллаж байгаа гэв.

5. Иргэн Гантуяа: Ираны дайн болон түлшний үнэ ханш тээвэрт хэрхэн нөлөөлөх вэ?

Хурлын дарга Г. Хишигбат хариулсан нь:

Ираны хажуугаар өнгөрдөг Ормузын хоолойгоор түүхий нефтийн 20 хувь нь тээвэрлэгддэг байсан нь сааталд орж, улмаар нийлүүлэлтийн тасалдлаас болж ялангуяа Азийн улсуудад бензин шатахууны үнэ өссөн, энэ нь тээврийн үнэд шууд нөлөөлдөг, өнгөрсөн хугацаанд агаарын тээврийн үнэд 20-70% өсөлт гарсан, Замын Үүд-УБ руу нэг автын үнэ 3,5 сая байсан бол одоо 5 сая болж өссөн, төмөр замын тээвэр одоогоор өсөөгүй байгаа ч энэ байдал үргэлжилбэл үнэ өсөх нь гарцаагүй юм, далайн тээвэр хамгийн бага өссөн буюу 10% орчим өсөөд байгаа ч, энэ нь өргөн хэрэглээний барааны үнэ өсөх, иргэдийн худалдан авах чадвар буурах гээд олон сөрөг нөлөөлөл бий болгохоор байна. Бид шатахууны үнэд нөлөөлж чадахгүй ч, шатахууныг тасалдахгүй байх тухайд нь шатахууны нийлүүлэгч компаниудтай хамтран ажиллаж байна.

6. Иргэн Буянзаяа: Баганхангай-Хөшгийн хөндийн төмөр замын бүтээн байгуулалт салбарт болон компанид хэрхэн нөлөөлөх вэ?

Хурлын дарга Г. Хишигбат хариулсан нь:

2025 онд салбарт хийгдсэн бас нэг том ажил бол Багахангай-Хөшгийн хөндийн бүтээн байгуулалын ажил байлаа, энэ жил Багахангай-Хөшгийн хөндийгөөр дамжаад Эмээлт чиглэлд тавигдах төмөр зам ашиглалтад орвол УБ хотоор дамжин өнгөрөх ачаа, тээврийн нөхцөл байдал өөрчлөгдөх хүлээлттэй байна.

Ложистик форум арга хэмжээ 5 сарын 22-ны өдөр болно, энэ үеэр хэлэлцэгдэх нэг чухал сэдэв нь Багахангай-Хөшгийн хөндий бүтээн байгуулалттай холбоотой асуудал байхаар төлөвлөж байгаа, та бүхэн энэ форумд оролцож, илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой гэдгийг хэлье гэснээр асуулт хариултын хэсэг өндөрлөв.

Санал өгөх зааврыг Хурал зохион байгуулах комиссын дарга Ц. Дуламсүрэн танилцуулж, санал хураалтын 10 минут эхэлснийг мэдэгдэв.

Санал өгөх болон тоолох хугацаа нийт 15 минут үргэлжлэв.

Тооллогын комиссын дарга Э. Нарангавуу Хурлын санал хураалтын дүнг дараах байдлаар танилцуулав. Хурлаар дараах асуудлыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

1. “Монложистикс Холдинг ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж шийдвэрлэх” асуудлаар санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
324,127,836	99.99993%	220	0.00007%	0	0%
Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5-д заасны дагуу шийдвэр 99.99993 хувиар хүчинтэй.					

2. “Монложистикс Тракинг” ХХК-ийг “Монложистикс Холдинг” ХК-тай нэгтгэх тухай асуудлаар санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
324,127,836	99.99993%	220	0.00007%	0	0%
Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5-д заасны дагуу шийдвэр 99.99993 хувиар хүчинтэй.					

Хурлын дарга Г. Хишигбат санал хураалтын дүнтэй танилцаад хурлаас дараах шийдвэр гарсан тухай танилцуулав. Үүнд:

Шийдвэр 1: “Монложистикс Холдинг” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлав.

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Монложистикс Холдинг” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.10.1 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. “Монложистикс Холдинг” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг баталсугай.
2. Энэхүү шийдвэрийг болон шаардлагатай баримт бичиг, мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу олон нийтэд мэдээлэх, Санхүүгийн

зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхийг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга /Ц. Дуламсүрэн/-д даалгасугай.

Шийдвэр 2: Монложистикс Тракинг ХХК-ийг Монложистикс Холдинг ХК-д нэгтгэхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг батлав.

Компанийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.2, 20.4 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.2 дахь заалт, “Монложистикс Холдинг” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.2 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. “Монложистикс Тракинг” ХХК-ийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлага, хөрөнгө, өр төлбөрийг бүхэлд нь “Монложистикс Холдинг” ХК-д нэгтгэсүгэй.
2. Монложистикс Тракинг ХХК нь Монложистикс Холдинг ХК-ийн 100 хувийн охин компани байсан болохыг дурдсугай.
3. “Монложистикс Тракинг ХХК”-ийг “Монложистикс Холдинг” ХК-д нэгтгэх тухай Төлөөлөн удирдах зөвлөлөөс танилцуулсан компани нэгтгэх гэрээг байгуулахыг зөвшөөрсүгэй.
4. “Монложистикс Холдинг” ХК-ийг төлөөлж Компани нэгтгэх гэрээнд гарын үсэг зурах, нэгтгэх үйл ажиллагаанд Компанийг төлөөлөх эрхийг Гүйцэтгэх захирал /Г.Хишигбат/-д олгосугай.
5. Нэгтгэх үйл ажиллагааг хуульд заасан журмын дагуу хийж гүйцэтгэж, тайлагнаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Г.Хишигбат/-д үүрэг болгосугай.
6. Энэхүү шийдвэрийг болон шаардлагатай баримт бичиг, мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу олон нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхийг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга /Ц. Дуламсүрэн/-д даалгасугай.

Хурлын дарга хурлыг хааж үг хэлэв.

Хурал 13 цаг 00 минутад өндөрлөв.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга  Ц. Дуламсүрэн

Хянасан:

Хурлын дарга

 Г. Хишигбат

